



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 4/Б

Чингис хот

**Комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дата төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Ж.Энхбат	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Баяртуяа	АЗДТГ-ын нярав
	Б.Мөнхжаргал	"Дөл БГМ" ХХК-ийн менежер

2. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дата төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга /Ж.Энхбат/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР